

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД (БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН)-ЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД 2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДРҮҮДЭД ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН ТАЛБАЙД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР

2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Зорилго: Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудад сурталчлан таниулах, иргэдийн санал, зөвлөгөөг сонсох, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний салбарын үйлчилгээг иргэдэд нэг дороос хүртэх боломжийг олгоход оршино.

Хэрэгжүүлэгч нэгж: Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба

Зохион байгуулах хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, 09:00-18:00 цагт

Хаана: Улаанбаатар хот, Жанжин Д.Сүхбаатарын талбай

Оролцох байгууллага: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт харьяа байгууллага, агентлагууд

Зохион байгуулах үзэсгэлэн, худалдаа: Төр, хувийн хэвшил, орон нутгийн хамтарсан өдөрлөг зохион байгуулна.

Хэвлэл, мэдээлэл: “Нээлттэй микрофон” ажиллуулах.

Гарах үр дүн:

- Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилна.
- Иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай үзүүлнэ.
- Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөлтөд иргэдийн санал сэтгэгдлийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган ажиллана.
- Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулагчдад танилцуулга хийнэ.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД (БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОНЦГОЙ
БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН)-ЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-НЫ ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР**

Хэзээ: 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр.

Оролцох байгууллагууд: Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТУГ, Үндэсний итгэмжлэлийн төв, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Цагааннуур чөлөөт бүс, Замын-Үүд чөлөөт бүс, Алтанбулаг чөлөөт бүс, Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс.

Хугацаа	Сэдэв	Оролцогч
	Монгол Улсын төрийн дуулал	<i>ОБЕГ-ын чуулга</i>
	Хүндэт зочдын танилцуулга	<i>Хөтлөгч</i>
	Нээлтийн үг	<i>Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр</i>
	Нээлтэй хаалганы өдөрлөгийн талаарх товч мэдээлэл	<i>Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил</i>
	Урлагийн болон дроны үзүүлбэр	<i>ОБЕГ-ын дэргэдэх Үндэсний аврах бригад</i>
	111 дүгээр ангийн нислэг болон Үндэсний аврах бригадын алба хаагчдын шүхрийн буултын үзүүлбэр	<i>ОБЕГ</i>
	Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны танилцуулга шторк	<i>ОБЕГ</i>
	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын танилцуулга шторк	<i>БХҮХ</i>
	Монгол Улсын тохирлын үнэлгээ, лаборатори, итгэмжлэлийн бодлогын танилцуулга шторк	<i>СХЗГ, ХАБҮЛЛ, ҮИТ</i>
	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгөх, сургалт хийх	<i>ОБЕГ</i>
	Монгол Улсын чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлогын танилцуулга шторк	<i>Чөлөөт бүсүүд</i>
	Урлагийн, албаны нохойн, гал унтраах, аврах ажиллагааны үзүүлбэр	<i>ОБЕГ-ын дэргэдэх Үндэсний аврах бригад</i>
	Нээлттэй микрофон	<i>ААН, холбоод, хөрөнгө оруулагчдын төлөөлөл</i>
	Хүүхэд, залуучуудад зориулсан асуулт хариулт, хөгжөөнт тэмцээн	<i>ОБЕГ</i>
	Оролцогч байгууллагуудад талархал гардуулах ёслол	<i>Шадар сайдын Ажлын алба, Харьяа агентлаг, байгууллагууд</i>
	Нээлттэй хаалганы өдөрлөгийн хаалтын үг	<i>Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил</i>

Жич: Харьяа байгууллагууд иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ,
БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ (ДЭЛГЭРЭНГҮЙ)**


д/д	Харьяа байгууллагын нэр	Оролцоо	Зохин байгуулалт
1	Онцгой байдлын ерөнхий газар	<u>Зорилго:</u> Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилна.	• Өдөрлөгийн талбайн эцсийн бэлтгэл, техник хэрэгсэл байршуулалт, оролцогчдын бүртгэл • Нээлтийн ажиллагаа • Урлагийн тоглолт • Удирдлагын мэндчилгээ- Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны танилцуулга • Гал унтраах, аврах ажиллагааны үзүүлэх тоглолт • Тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн тайлбарт үзүүлэн • Анхны тусламж, CPR үзүүлэх сургалт • Иргэдийн оролцоотой галын хор ашиглах дадлага • Албаны нохойн үзүүлбэр • Дроны үзүүлбэр, эрэн хайх болон хяналт тандалтын зориулалтын танилцуулга • Чөлөөт үзвэр, үзэсгэлэнгийн талбайтай танилцах • Нисдэг тэрэг/онгоц буух үзүүлбэр, нисэх ажиллагааны тайлбар • Уснаас, өндрөөс, нурангинаас аврах ажиллагаанд ашиглагдах багаж хэрэгслийн танилцуулга • Хүүхэд, залуучуудад зориулсан асуулт хариулт, хөгжөөнт тэмцээн • Алба сурталчлах, мэргэжил, элсэлтийн мэдээлэл • Хамтран ажиллагч байгууллагын оролцоо, танилцуулга • Идэвхтэй оролцогчдод дурсгал гардуулах
2	“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ	<u>Зорилго:</u> •Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилтийг олон нийтэд таниулан, сурталчлах <u>Оролцох байдал:</u> Танилцуулга, сурталчилгаа •Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн танилцуулга •Орон нутгийн хөгжлийн индексийг танилцуулга	Асарт үзэсгэлэнгийн булан гаргах: • Дижитал дэлгэц (видео танилцуулга) • Тараах материал

		•Бүсчилсэн хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлага, мониторингийн орон зайн нэгдсэн системийн дашбоардын танилцуулга •Эдийн засгийн тусгай бүсийн судалгаа •Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын ТЭЗҮ, зураг төслийн талаарх танилцуулга •Бүсийн шторк, танилцуулга •Судалгааны үр дүнгийн танилцуулга	
3	Стандарт, хэмжил зүйн газар	<u>Зорилго:</u> Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт Стандарт, хэмжил зүйн газраас төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэнэ. Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах бөгөөд Тохирлын үнэлгээнд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын бараа бүтээгдэхүүнийг тус өдөрлөг арга хэмжээнд оролцуулах боломжтой. Үр дүнд нь иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийг Нээлттэй хаалганы өдөрлөгт идэвхтэй хамруулна.	<u>Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр үзүүлэх үйлчилгээ:</u> • Стандартын борлуулалт, мэдээлэл, лавлагааны үйлчилгээ • Эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээ • Зарим Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажил үйлчилгээ • Лабораторийн үйл ажиллагааны танилцуулга, мэдээлэл.
4	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	<u>Зорилго:</u> Иргэд, аж ахуйн нэгж байгууллагад Хүнсний аюулгүй байдлын шинжилгээний талаар мэдлэг ойлголт өгөх, хүнсний бүтээгдэхүүн, орчны дээжид зөөврийн багажаар болон түргэвчилсэн арга аргачлалаар газар дээр нь шинжилгээ хийж, шинжилгээний үйл ажиллагааг таниулах	<u>Иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээ:</u> • Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэнд пестицидийн үлдэгдлийг түргэвчилсэн багажаар тодорхойлох шинжилгээ хийх • Гол мөрөн, булаг шандны усанд зөөврийн багажаар химийн шинжилгээ хийх • Хоолны хордлого, хордлогот халдвар үүсгэгч зарим бактерийг танилцуулах /бактерийн өсгөвөрийн наалдацыг микроскопоор харуулах/ • Төмс, хүнсний ногоонд илэрдэг хөнөөлт шавьж, ургамлын өвчний үзүүлэн, таниулах материалын үзэсгэлэн гаргах

			- Ундны усанд цацраг идэвхит радон тодорхойлох шинжилгээ хийх - Эд зүйлст цацрагийн бохирдолыг газар дээр нь тодорхойлох шинжилгээ хийх /автомашин, тоног төхөөрөмж, эд материал гэх мэт/ - Лабораторийн үйл ажиллагааны талаархи танилцуулга, постер байршуулах, мэдээ мэдээлэл өгөх, зөвлөмж материал тараах
5	Үндэсний итгэмжлэлийн төв	<u>Зорилго:</u> Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд (сорилт, шалгалт тохируулга, эрүүл мэндийн лаборатори, техникийн хяналт, баталгаажуулалтын байгууллага)-ын нийгэм эдийн засагт үзүүлэх үр ашгийг сурталчлах.	Нээлттэй хаалганы өдөрлөгт Үндэсний итгэмжлэлийн төв 1 асар, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудад 5-8 асар байхаар төлөвлөж байна. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагад уул уурхайн бүтээгдэхүүний сорилтын лаборатори, эрүүл мэндийн лаборатори болон техникийн хяналт, баталгаажуулалтын байгууллагын төлөөллийг оролцуулах боломжтой. Тайлбар: Шаардлагатай тохиолдолд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын оролцох асрын тоог нэмэгдүүлэх боломжтой.
6	Замын-Үүд чөлөөт бүс	<u>Зорилго:</u> - Чөлөөт бүсийн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах - Хөрөнгө оруулалтын боломжийг танилцуулах - Бизнес эрхлэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх.	1.Танилцуулга, сурталчилгаа - Чөлөөт бүсийн эрх зүйн орчин - Хөгжлийн төлөвлөгөө - Давуу тал (татвар, гаалийн хөнгөлөлт) - Видео танилцуулга - Хөрөнгө оруулалтын төслүүдийн танилцуулга 2.Үйлчилгээ, зөвлөгөө Бизнес эрхлэгчдэд: - Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх боломж - Бүртгэл, зөвшөөрлийн талаар зөвлөгөө 3.Хөрөнгө оруулагчдад: - Хөрөнгө оруулалтын орчин - Түншлэл, хамтын ажиллагааны мэдээлэл 4.Иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа: - Асуулт, хариултын булан - Санал, хүсэлт хүлээн авах Бусад. Үзүүлэн, зохион байгуулалт: Үзэсгэлэнгийн булан ажиллуулна. - Чөлөөт бүсийн хөгжлийн зураглал - Фото самбар (одоо ба ирээдүй) - Дижитал дэлгэц (видео танилцуулга) Иргэд, олон нийтэд материал тараана. - Танилцуулга брошюр - Хөрөнгө оруулалтын гарын авлага - QR код бүхий мэдээлэл
7	Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс	<u>Зорилго:</u> Чөлөөт бүсийн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Чөлөөт бүс Жанжин Д.Сүхбаатарын талбай дээр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт өөрийн байгууллагын үйл ажиллагаагаа

		• Хөрөнгө оруулалтын боломжийг танилцуулах • Бизнес эрхлэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх.	танилцуулах, одоогийн явцыг харуулах, дотоод гадаадын иргэн, аж ахуй нэгж хөрөнгө оруулах боломжтойг танилцуулахад 1 асар шаардлагатай байна.
8	Цагааннуур чөлөөт бүс	<u>Зорилго:</u> Жанжин Д.Сүхбаатарын талбайд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт тус чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны нийт албан хаагчид оролцож, чөлөөт бүсэд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж, иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилна.	Иргэд, олон нийтэд чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд: -Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэдэд мэдээлэл өгөх -Цагааннуур чөлөөт бүсэд хэрэгжих аж ахуйн нэгжүүдийн төслүүдийн талаар танилцуулга (аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулах) -Чөлөөт бүс дэх гааль, татварын хөнгөлөлтийн талаар мэдээлэл өгөх -Видео шторк (Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн газар олголт, төсөл сонгон шалгаруулалтын талаар танилцуулах, дэд бүтэц) - Салбарын хууль тогтоомжийг сурталчлах -Хөгжлийн тэргүүлэх чиглэл болох логиستيкийн талаар зохиомж танилцуулга, мөн бизнес боломжийн үлгэрлэсэн видео танилцуулга - Иргэдийн санал хүсэлт сонсох.
9	Алтанбулаг чөлөөт бүс	<u>Зорилго:</u> Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 онд зохион байгуулах Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны арга хэмжээнд оролцож “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулна.	“Алтанбулаг чөлөөт бүс” нэртэй асар босгох, иргэд, аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай мэдээллээр ханган, олонд нээлттэй ажиллана. Монгол Улсын Шадар сайдын зохион байгуулж буй дээрх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээнд сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА



Улаанаар хүрээлсэн хэсэгт асар, техник, тоног төхөөрөмжүүд, тусгай зориулалтын автомашин байна.

